

IDI - In Depth Interview

Ганцаарчилсан ярилцлагын арга

Ганцаарчилсан ярилцлага нь судлаач респондент буюу ярилцлаганд оролцогчтой биечлэн уулзан ярилцаж (face to face) түүний үзэл бодол, хүсэл эрмэлзлэл, хувийн санаа бодол, үнэлэлт, дүгнэлтийн талаар илүү гүнзгийрүүлэн ярилцаж мэдээлэл цуглуулдаг арга юм.

Мөн судлагдах зүйлийн сэдэв хувь хүний нууцтай холбоотой эсвэл эмзэг асуудлын талаар, цаг зав багатай байдаг өндөр орлоготой бүлэг, байгууллага хэрэглэгч, аль эсвэл тухайн асуудлын талаар илүү нарийн мэдээлэл шаардлагатай бол ганцаарчилсан ярилцлагын аргын ашиглах нь тохиромжтой байдаг. Ингэснээр судалгаанд оролцогчийн санал бодлыг бусдын ямар нэгэн нөлөөгүйгээр зөвхөн тухайн хувь хүний санаа бодлыг ойлгох боломжтой юм.